

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ЭМИЙН  
ЖАГСААЛТ, ХОЛБОГДОХ ЖУРМЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ”  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**2024.01.26**

**Улаанбаатар хот**

**Нэг. Хууль зүйн үндэслэл:**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулинд “Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт”-ыг батлахтай холбоотой дараах зохицуулалтууд байдаг. Үүнд:

1.1 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.3-т “Даатгуулагч Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.1, 15.1.2, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.9, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагын эмчийн бичсэн жороор эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон ерөнхий нэршлийн эмийг тухайн эрүүл мэндийн байгууллагын эмийн сан, бусад эмийн сангаас худалдан авах тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлнэ.” гэж;

1.2 Тус хуулийн 14.9.10-т “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох” гэж

1.3 Тус хуулийн 9.1.13-т “Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.1, 24.6.2, 24.6.5-24.6.8, 24.6.10, 35.3-т заасан эмнэлгийн тусламж үйлчилгээ” нь Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад хамаарна гэж тус тус заасан байдаг.

Мөн түүнчлэн тус хуулийн 16.1.6-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь хөнгөлөлттэй эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээний асуудлаар санал боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Үндэсний зөвлөлөөр шийдвэрлүүлэх үүргийн хүрээнд энэхүү тогтоолын төслийг боловсрууллаа.

**Хоёр. Өнөөгийн нөхцөл байдал:**

Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор баталсан Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт олгох тусламж, үйлчилгээ нь дараах байдлаар хэрэгжиж байна. Үүнд:

2.1. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөнгөлөлттэй эмийн жагсаалтаар 125 өвчний үед хэрэглэх 161 ерөнхий нэршилд хамаарах 651 худалдааны нэршлийн эмийг 30, 50, 70 хувийн, 0-19 хүртэлх насны хүүхдэд уналт, таталтын эсрэг эмийг болон “Новартис эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх

хөтөлбөрийн” эмүүдийг эрүүл мэндийн даатгалын сангаас тус тус 100 хувиар хөнгөлж байна.

2.2. Хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээг 2023 оны байдлаар давхардаагүй тоогоор нийт 645,560 мянган даатгуулагч авсан буюу Монгол Улсын нийт хүн амын 18 хувьд нь хүрч байна. Тухайн тусламж, үйлчилгээг авч байгаа даатгуулагчдын хувьд 2020 онтой харьцуулахад 62 хувиар өссөн нь хүртээмж нэмэгдэж байгааг харуулж байна. Мөн хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээг авч байгаа нийт даатгуулагчийн 51 хувийг тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй даатгуулагч буюу 2 даатгуулагч тутмын 1 нь өндөр настан байна.

2.3. Хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээний хүрээнд 2023 онд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлсэн мөнгөн дүнгийн хувьд нэг иргэнд хамгийн их нь 11 сая, дундаж нь 21 мянган төгрөг байгаа бол иргэний өөрөө хариуцан төлсөн төлбөрийн хувьд жилдээ хамгийн их нь 4.7 сая төгрөгийг, дунджаар 16 мянган төгрөгийг төлсөн байна. Даатгуулагчид артерийн даралт ихсэх өвчин, элэгний хатуурал, чихрийн шижин, ходоодны үрэвсэл, В, С вирусын халдвар болон уналт, таталт өвчний оношоор хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээг хамгийн ихээр авсан байна.

### **Гурав. Хөнгөлөлттэй эмийн жагсаалт, журмыг шинэчлэх үндэслэл, шаардлага**

Тогтоолын төслийг шинэчлэх дараах үндэслэлүүд бий болсон байна. Үүнд:

Нэг. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.3-т заасанчлан “Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт”-ыг үндэсний хэмжээнд мөрддөг Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад үндэслэн тодорхойлдог. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөнгөлөлттэй эмийн жагсаалт нь ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсанаас хойш буюу 2023 онд Монгол Улсын зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт болон хүүхдийн зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт тус тус шинэчлэн батлагдсан байна. Тодруулбал:

- Эрүүл мэндийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/197 дугаар тушаалаар “Зайлшгүй шаардлагатай эмийн 10 дугаар жагсаалт” батлагдсан бөгөөд энэхүү жагсаалтад ЭМДС-аас эмийн хөнгөлөлт үзүүлэх өвчин эмгэгийн эмчилгээний 2 ерөнхий нэршлийн эм шинээр нэмэгдэж, жагсаалтад байсан 1 ерөнхий нэршлийн эм хасагдсан байна.
- Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Жагсаалтад нэмэлт оруулах тухай” А/408 дугаар тушаалаар ерөнхий нэршлийн 2 эмийг нэмж оруулсан байна.
- 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/408 дугаар тушаалаар “Хүүхдийн зайлшгүй шаардлагатай эмийн 3 дахь жагсаалт” батлагдсан бөгөөд энэхүү жагсаалтад ЭМДС-аас эмийн хөнгөлөлт үзүүлэх өвчин эмгэгийн эмчилгээний 1 ерөнхий нэршлийн эм шинээр нэмэгдсэн байна.

Иймд шинэчлэн батлагдсан зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалттай уялдуулан хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг шинэчлэх үндэслэл бүрдсэн.

Хоёр. Эрүүл мэндийн даатгалын сангаас худалдан авах аливаа тусламж, үйлчилгээг тодорхойлохдоо хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эмнэлзүйн хувьд үр дүнтэй, эдийн засгийн хувьд ашигтай тусламж, үйлчилгээг цогц байдлаар худалдан авах замаар сангийн үр ашгийг дээшлүүлэх зарчмыг баримталдаг. Энэхүү зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд ЭМДС-аас худалдан авч, санхүүжүүлэхээр тодорхойлогдсон анхан шатны болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын өөрчлөлтүүдэд тусгагдсан бодлогуудтай уялдуулан хөнгөлөлттэй эмийн жагсаалт, журмыг өөрчлөх шаардлага тулгараад байна. Тухайлбал: Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 08 дугаар тогтоолоор хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнээс лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад хэвтүүлэн эмчлэх шаардлагагүй зургаан оношийн хамааралтай бүлгийг хасаж, тухайн эмгэгээр өвчилсөн даатгуулагчдыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нь хяналтад байлгах, өдрөөр эмчлэх бодлогыг нэвтрүүлсэн боловч хэрэгжилтийн түвшинд төдийлөн үр нөлөөгөө өгөхгүй байна. Ийнхүү дорвитой өөрчлөлт бий болохгүй байгаа нь эдгээр өвчин, эмгэгүүдийг эмчлэх зарим эмүүд хөнгөлөлттэй эмийн жагсаалтад байхгүй байгаатай холбоотой байх тул эдгээр эмүүдийг жагсаалтад зайлшгүй нэмэх, эмчилгээ үйлчилгээг зохистой түвшинд нь цогцоор үзүүлэх олон улсын стандартад нийцүүлэх шаардлага үүсээд байна.

Гурав. Хөнгөлөлттэй эмийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийн үзэхэд одоогийн жагсаалт, холбогдох журмуудыг зайлшгүй өөрчлөх, зохицуулалтуудыг нарийн болгох шаардлага тулгарсан. Тодруулбал:

3.1. ДЭМБ-ын тайланд дурдсанаар 2018 оны байдлаар Монгол Улсын хүн амын эрүүл мэнддээ төлсөн шууд төлбөр буюу халаасны төлбөрийн 70 гаруй хувь нь эм худалдан авахдаа төлсөн төлбөр байгаа бөгөөд энэ нь ядуу хүн амын хувьд 81 хувьтай, орлого өндөртэй хүн амын хувьд 60 орчим хувьтай байна. Энэхүү үзүүлэлтээс үзэхэд Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэхийн тулд хөнгөлөлттэй эмийн хүртээмж, жагсаалт, бодлогод өөрчлөлт оруулах шаардлагатай байгааг харуулж байна.

3.2. Хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээнд дүн шинжилгээ хийж үзэхэд хавсарсан, архаг өвчтэй, насанд туршдаа эм хэрэглэх шаардлагатай даатгуулагч өндөр хамтын төлбөр төлдөг, төлж буй хамтын төлбөр нь бусад бага болон дундаж орлоготой орнуудтай харьцуулахад их байна. Тухайн асуудлыг шийдвэрлэхийн тулд хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээний хамтын төлбөрийг бууруулах бодлогын зохицуулалт хийх, уг зохицуулалтыг хамгийн түрүүнд хавсарсан архаг өвчтэй, насан туршдаа эм хэрэглэх шаардлагатай даатгуулагчидруу чиглэх шаардлагатай нөхцөл байдал үүсээд байна.

3.3. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хугацаанд гэрээт эмийн сангууд даатгуулагчдад хөнгөлөлттэй эмийн жороор үйлчлэхээс татгалзан гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчих, өвчний оношийн баталгаажуулалтгүйгээр эмийг зохисгүй хэрэглэх, эмийн сан болон эрүүл мэндийн байгууллагууд ашгийн төлөө үгсэн хуйвалдаж эрүүл мэндийн даатгалын санг санаатайгаар хохироох асуудлууд үүссэн нь мөн тухайн тогтоолыг шинэчлэх шаардлагатай байгааг харуулж байна.

**Дөрөв. Тогтоолоор баталсан журам, жагсаалтын ерөнхий зохицуулалт, бүтэц:**

Энэхүү ““Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт, холбогдох журмыг шинэчлэн батлах тухай” тогтоолын төслөөр дараах өөрчлөлтүүдийг оруулаад байна.

1. “Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт олгох үзүүлэх, санхүүжүүлэх журам”-ын эмч, эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг хэсэгт урт хугацааны эмчилгээ шаардлагатай даатгуулагчдыг харьяалал бүхий анхан шатны эрүүл мэндийн байгууллага нь хянахаар тусгасан.
2. “Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-д дараах өөрчлөлтүүдийг оруулсан. Үүнд:
  - 2.1. Нэг удаагийн импортын лицензээр оруулж ирсэн Монгол Улсын эмийн бүртгэлд албан ёсоор бүртгэгдээгүй байгаа 23 ерөнхий нэршлийн уналт, таталтын эсрэг эмийг одоогийн мөрдөгдөж байгаа хөнгөлөлттэй эмийн жагсаалтад түр зохицуулалтаар оруулсан байсанг Монгол Улсын засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 33 дугаар тэмдэглэлийн 2.1 дэхь заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/407 тоот тушаалд тус тус заасны дагуу Төлбөрийг нь төр хариуцах эмийн жагсаалтруу оруулсан;
  - 2.2. Монгол Улсын зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад багтаагүй 7 ерөнхий нэршлийн эмийг хөнгөлөлттэй эмийн жагсаалтаас хассан;
  - 2.3. Зарим өвчнийг зөвхөн амбулатори болон өдрөөр эмчилдэг болсонтой холбоотой тухайн оношуудад хамаарах эмүүд нэмэгдсэнээр жагсаалтад байх эмийн тоо 651-ээс 742 болж нэмэгдсэн.
  - 2.4. Хөнгөлөлтийн хувьд дараах өөрчлөлтийг оруулсан. Үүнд:
    - 30 хувийн хөнгөлөлттэй эмийн тоо 35-аас 56 болж 21-ээр нэмэгдсэн;
    - 50 хувийн хөнгөлөлттэй эмийн тоо 163-аас 390 болж 227-оор нэмэгдсэн;
    - 70 хувийн хөнгөлөлттэй эмийн тоо 304-өөс 272 болж 32-оор буурсан;
    - 100 хувийн хөнгөлөлттэй эмийн тоо 24 буюу хэвэндээ
  - 2.5. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.7-д зааснаар “Олон Улсын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг нэг эх үүсвэрээс худалдан авах журам” Монгол Улсын Засгийн газраас баталсны дагуу энэхүү тогтоолын төслийг үнийн дээд хязгаарыг нэмэгдүүлэлгүй боловсрууллаа.

## **Тав.Тогтоолын өөрчлөлтөөс хүрэх үр дүн**

“Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт, холбогдох журмыг шинэчлэн батлах тухай” тогтоолыг шинэчлэн батлуулсанаар дараах үр дүнд хүрэхээр зорьж байна. Үүнд:

1. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага нь өөрийн харьяанд байх урт хугацааны эмчилгээ шаардлагатай даатгуулагчдыг тогтмол хянадаг болох;
2. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт дахь эмийн үнийн дээд хязгаар нэмэгдсэнээр эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулсан нийтийн үйлчилгээтэй эмийн сангууд даатгуулагчдад хөнгөлөлттэй эмийн жороор хүндрэл чирэгдэлгүй үйлчлэх;
3. Даатгуулагчдын хөнгөлөлттэй эмийн жороор шаардлагагүй эмийг авч хэрэглэх, эмийн зохисгүй хэрэглээний асуудал үе, шаттайгаар шийдэгдэх зэрэг болно.
4. Урт хугацаанд тогтмол эм уудаг болон олон төрлийн архаг өвчтэй, орлого багатай иргэдийг эмийн хамтын төлбөрөөс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах боломж үүснэ.

Иймд тогтоолын төслийг боловсруулан Захиргааны ерөнхий хуулийн 62.1-т заасны дагуу санал авахаар байршуулж байна.

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**